

ЧАНАР, ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Эрүүл мэндийн даатгалын сан (ЭМДС)- аас иргэн даатгуулагчийн эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн, эмнэл зүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай тусламж, үйлчилгээг худалдан авах, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, ЭМДС-ийн нөөц ашиглалтыг үр ашигтай болгох зорилгоор ЭМДС-аас худалдан авах тусламж, үйлчилгээнд чанар, төлбөрийн хяналтын арга хэмжээг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Чанарын хяналтын зорилго нь эрүүл мэндийн байгууллага (ЭМБ)-аас иргэн, даатгуулагчдад чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээг үзүүлэх хөшүүргийг бий болгох, иргэдийн эрүүл мэндийн үр дүнг сайжруулах, иргэн, даатгуулагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт тулгарч буй асуудлыг илрүүлж, цаашид сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино.
- 1.3. Төлбөрийн хяналтын зорилго нь ЭМДС-д санхүүгийн хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, болзошгүй санхүүгийн хохирлыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах замаар ЭМДС-г аливаа санхүүгийн хохирлоос хамгаалахад оршино.

Хоёр. Чанар, төлбөрийн хяналтын төрөл, хяналт хийхэд баримтлах зарчим

- 2.1. ЭМДЕГ-аас хэрэгжүүлэх төлбөрийн хяналт нь дараах төрлүүдтэй байна:
 - 2.1.1. Нэхэмжлэлийг хүлээн авах урьдал нөхцөл шалгах
 - 2.1.2. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналт
 - 2.1.3. Төлбөрийн хэмжээг нягтлах хяналт
 - 2.1.4. ЭМБ дээр хийх тусгайлсан хяналт шалгалт
- 2.2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (ЭМДЕГ)-аас хэрэгжүүлэх чанарын хяналт нь дараах төрлүүдтэй байна:
 - 2.2.1. Нэхэмжлэлийн чанарын хяналт
 - 2.2.2. Эмнэлзүйн аудит
 - 2.2.3. ЭМБ дээр хийх тусгайлсан хяналт шалгалт
 - 2.2.4. Гэрээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
 - 2.2.5. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа
- 2.3. Чанар, төлбөрийн хяналтыг хийхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 2.3.1. Бие даасан байх – ЭМДЕГ нь чанарын хяналтыг хараат бусаар, бие даан гүйцэтгэх, аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
 - 2.3.2. Иргэн, даатгуулагчийн эрх ашгийг дээдлэх – Иргэн даатгуулагчийн эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурлах, аюулгүй байдлыг хангах;
 - 2.3.3. Анагаах ухааны нотолгоонд тулгуурласан байх – Чанар, төлбөрийн хяналтад анагаах ухааны нотолгоонд суурилсан олон улсад ашигладаг эмнэлзүйн удирдамжийг ашиглах;
 - 2.3.4. Шударга, тэгш байдлыг хангах – Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагад адил тэгш хандах;
 - 2.3.5. Чанарын хяналтын тогтолцоог бэхжүүлэх – Чанарыг тасралтгүй сайжруулахад чиглэсэн дэмжлэгт хяналт, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, эргэх холбоог тогтоох;
 - 2.3.6. Хяналтын тогтолцооны сайн туршлагыг байнга эрэлхийлдэг байх – Хяналт, үнэлгээний үйл явцыг боловсронгуй болгох, тасралтгүй сайжруулах, ижил төстэй тогтолцоо бүхий бусад улс орны сайн туршлагаудыг судлах, нутагшуулах, нэвтрүүлэх зэрэг болно.

Гурав. Чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

- 3.1. ЭМДЕГ нь чанар, төлбөрийн хяналтыг хяналт хийх аргаас хамааруулан сар бүр, нөхцөл бүрдсэн тохиолдолд, жилд 1 удаа, жилд 2 удаа гэсэн хугацаатайгаар тус тус хийнэ. Үүнд:
 - 3.1.1. Энэхүү журмын 2.1.4, 2.2.3-т зааснаас бусад чанар, төлбөрийн хяналтуудыг ЭМБ-аас илгээсэн зорилтот нэхэмжлэл¹ эсвэл баталгаажсан нэхэмжлэл²-д сар бүр хийнэ.
 - 3.1.2. Энэхүү журмын 2.1.5-т заасан чанарын хяналтын төрлийг хагас, бүтэн жилээр буюу 2 удаа гүйцэтгэнэ.
 - 3.1.3. Энэхүү журмын 2.1.2-т заасан чанарын хяналтыг сонгогдсон тусламж, үйлчилгээний хүрээнд жилийн турш тасралтгүй, 2.1.4-т заасан чанарын хяналтыг жилийн эцэст 1 удаа гүйцэтгэнэ.
 - 3.1.4. Энэхүү журмын 2.1.3, 2.2.4-т заасан чанар, төлбөрийн хяналтыг хослуулан хийх боломжтой төрөл болох “ЭМБ дээр хийх тусгайлсан хяналт шалгалт”-ыг нөхцөл бүрэлдсэн тухай бүр хийнэ.
- 3.2. Сар бүр хийх чанар, төлбөрийн хяналтыг чанар, төлбөрийн хяналтын төрлүүдийг хослуулан, ЭМБ-аас илгээсэн зорилтот болон баталгаажсан нэхэмжлэлд дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ³. Үүнд:
 - 3.2.1. Сар бүр хийх хяналтын үе шат 1: Нэхэмжлэлийг хүлээн авах урьдал нөхцөлийг шалгах
 - 3.2.2. Сар бүр хийх хяналтын үе шат 2: Нэхэмжлэлийн төлбөрийн хяналт хийх
 - 3.2.3. Сар бүр хийх хяналтын үе шат 3: Нэхэмжлэлийн чанарын хяналт хийх
 - 3.2.4. Сар бүр хийх хяналтын үе шат 4: Төлбөрийн хэмжээг нягтлах хяналт
- 3.3. Энэхүү журмын 3.2-т зохицуулснаас бусад чанар, төлбөрийн хяналтуудыг бие даасан байдлаар, үе шатгүйгээр дангаар хийнэ.

Дөрөв. Нэхэмжлэлийг хүлээн авах урьдал нөхцөл шалгах

- 4.1. ЭМДЕГ нь ЭМБ-ын нэхэмжлэлийг баталгаажуулж, албан ёсоор хүлээн авахаас өмнө тухайн зорилтот нэхэмжлэл нь “нэхэмжлэл хүлээн авах урьдал нөхцөл”-ийг хангасан эсэхийг шалгана.
- 4.2. Нэхэмжлэл хүлээн авах урьдал нөхцөлийг шалгах нь ЭМБ-ын нэхэмжлэлийг энгийн алдаанаас үүдэн амжилтгүй болохоос урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд энэ үе шатанд ЭМБ-ын илгээхийг зорьсон бүх тохиолдлын нэхэмжлэл буюу бүх “зорилтот нэхэмжлэл” бүрэн хамрагдана.
- 4.3. Даатгуулагчид тусламж үйлчилгээг үзүүлж дууссан өдрөөр тасалбар болгож анхан шатны маягтыг цахимаар илгээнэ.
- 4.4. ЭМД-д ирүүлсэн өвчтөний анхан шатны маягтыг цахим хэлбэрээр архив үүсгэж хадгална.
- 4.5. Нэхэмжлэл хүлээн авах урьдал нөхцөл гэдэгт дараах нөхцөлүүд хамаарна. Үүнд:
 - 4.5.1. Тухайн ЭМБ нь эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ үзүүлэх урьдчилсан нөхцөлийг хангасан эсэх:
 - 4.5.1.1. ЭМБ-ын тусгай зөвшөөрлийн хугацаа нь хүчин төгөлдөр эсэх;
 - 4.5.1.2. ЭМБ-ын магадлан итгэмжлэлийн хугацаа нь хүчин төгөлдөр эсэх;
 - 4.5.1.3. ЭМБ болон ЭМДЕГ хооронд байгуулсан гэрээ нь хүчин төгөлдөр эсэх;

¹ Зорилтот нэхэмжлэл гэдэг нь тухайн ЭМБ-ын тухайн сард илгээхийг зорьсон бүх тохиолдлын нэхэмжлэлийг хэлнэ.

² Баталгаажсан нэхэмжлэл гэдэг нь “Нэхэмжлэлийг хүлээн авах урьдал нөхцөл”-ийг бүрэн хангаж, ЭМДЕГ-ын нэхэмжлэл хүлээн авах системд “Нэхэмжлэл” хэмээн хүлээн зөвшөөрөгдөн, баталгаажсан нэхэмжлэлийг хэлнэ.

³ Сар бүр хийх чанар, төлбөрийн хяналтын үе шатны зураглалыг энэхүү журмын хавсралт 1-ээс харна уу.

- 4.5.2. Тухайн нэхэмжлэлийн тохиолдол нь ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлагдсан нэхэмжлэл илгээх, хүлээн авах мэдээллийг цахим системд үнэн зөв, бүрэн гүйцэт бөглөсөн эсэх.
 - 4.5.3. Тухайн нэхэмжлэлийн тохиолдол /нэгж/ нь ЭМБ болон ЭМДЕГ хооронд байгуулсан гэрээнд заагдсан тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээтэй тохирч буй эсэх.
 - 4.5.3.1. Гэрээнд заасан тусламж, үйлчилгээтэй нэр төрөлтэй тохирч буй эсэх.
 - 4.5.3.2. Гэрээнд заасан тусламж, үйлчилгээний тоо хэмжээний хүрээнд багтаж буй эсэх.
 - 4.5.4. Нэхэмжлэлд хамаарах тусламж, үйлчилгээг тухайн ЭМБ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтэн үзүүлсэн эсэх, тус эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй эсэх;
 - 4.5.5. Тухайн нэхэмжлэлийн тохиолдол нь ЭМДҮЗ-өөс баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлын тоог тооцох, санхүүжүүлэх журам” - ын нөхцөлийг хангаж буй эсэх.
- 4.6. Дараах нөхцөлүүдийн аль нэг нь хангагдсан тохиолдолд тухайн зорилтот нэхэмжлэлийн тохиолдлыг “нэхэмжлэл хүлээн авах урьдал нөхцөл” хангаагүйд тооцно. Үүнд:
 - 4.6.1. ЭМБ-ын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;
 - 4.6.2. ЭМБ-ын магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан;
 - 4.6.3. ЭМДЕГ болон ЭМБ хооронд байгуулсан гэрээний хугацаа дууссан эсвэл гэрээ хүчингүй болсон;
 - 4.6.4. Нэхэмжлэл илгээх, хүлээн авах мэдээллийн шаардлагыг хангаагүй буюу мэдээлэл дутуу илгээсэн эсхүл мэдээллийг буруу илгээсэн;
 - 4.6.5. ЭМБ болон ЭМДЕГ хооронд байгуулагдсан гэрээнд заагдаагүй тусламж, үйлчилгээгээр нэхэмжлэл илгээсэн;
 - 4.6.6. Тухайн тусламж, үйлчилгээний гэрээнд заасан тоо хэмжээ нь 100 хувь бүрэн нэхэмжлэгдэж дууссан;
 - 4.6.7. Нэхэмжлэлд хамаарах тусламж, үйлчилгээг тухайн ЭМБ-д бүртгэлтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн үзүүлээгүй;
 - 4.6.8. Нэхэмжлэлд хамаарах тусламж, үйлчилгээг үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчингүй болсон, хугацаа нь дууссан;
 - 4.6.9. ЭМДҮЗ-өөс баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлын тоог тооцох, санхүүжүүлэх журам” – ын дагуу цахим системд хийсэн бодлогын даалгавруудын аль нэг нөхцөлийг хангаагүй зэрэг болно.
 - 4.7. Нэхэмжлэл хүлээн авах урьдал нөхцөлийг цахимаар шалгана.
 - 4.8. ЭМДЕГ нь тухайн зорилтот нэхэмжлэлийн тохиолдол нь “нэхэмжлэлийн урьдал нөхцөл”-ийг хангасан эсэхээс нь хамаарч дараах арга хэмжээг авна. Үүнд:
 - 4.8.1. Нэхэмжлэлийн урьдал нөхцөлийг хангасан тохиолдлыг ЭМДЕГ-ын нэхэмжлэл хүлээн авах цахим системд “Нэхэмжлэл” хэмээн хүлээн зөвшөөрөн нэхэмжлэлийг баталгаажуулж, нэхэмжлэлийн төлбөрийн хяналтын үе шат руу шилжүүлнэ.
 - 4.8.2. Нэхэмжлэлийн урьдал нөхцөлийг хангаагүй тохиолдлыг ЭМДЕГ-ын цахим систем хүлээн авахаас татгалзах бөгөөд аль нөхцөлийг хангаагүйгээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй тухай мэдээллийн хамт ЭМБ руу буцаана. ЭМБ нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзан буцаагдсан тохиолдлыг хуанлийн 3 хоногийн дотор засварлан, буцаан илгээж болно. Нэхэмжлэл засах хугацаа хэтэрсэн тохиолдлыг хүлээн авахгүй.
 - 4.8.3. Засварлагдсан нэхэмжлэл нь энэхүү нэхэмжлэл хүлээн авах урьдал нөхцөлийг шалгах үе шатаар дахин шалгагдах бөгөөд урьдал нөхцөлийг амжилттай давсан тохиолдолд журмын 4.6.1 зохицуулалтын дагуу нэхэмжлэлийн төлбөрийн хяналтын үе шат руу шилжүүлэх, амжилтгүй тохиолдолд тухайн зорилтот нэхэмжлэлийн

тохиолдлыг хүлээн авахаас бүрэн татгалзах буюу дахин засварлан илгээх боломжгүй болно.

- 4.9. ЭМДЕГ нь ЭМБ-ын зорилтот нэхэмжлэлүүдийг “нэхэмжлэл хүлээн авах урьдал нөхцөл”-ийг хангахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.9.1. Гэрээлээгүй тусламж, үйлчилгээний төрлөөр нэхэмжлэхийг оролдсон тохиолдлуудыг бүртгэж, тухайн тохиолдол гаргасан ЭМБ руу улиралд нэг удаа албан бичгээр зөвлөмж өгнө.
- 4.9.2. ЭМБ-ын гэрээнд заасан тухайн тусламж, үйлчилгээний тоо хэмжээний 25 %, 50 %, 75 %-д хүрсэн тохиолдолд тус бүрд энэ тухай ЭМБ-д цахим мэдэгдэл хүргүүлнэ.
- 4.9.3. Нэхэмжлэлийг буруу, алдаатай бичиж илгээсэн, нэхэмжлэлийг засах эрх олгосон ч гүйцэлдүүлж чадаагүй тохиолдлуудыг бүртгэж, ЭМБ-уудад улиралд 1 удаа бичгээр зөвлөмж хүргүүлнэ.
- 4.9.4. Бодлогын даалгаврын нөхцөлүүдийг хангаагүй тохиолдлын төлбөрийн хасагдлын шалтгааныг нэгтгэж, улиралд 1 удаа холбогдох ЭМБ-д бичгээр хүргүүлнэ.
- 4.10. ЭМДЕГ нь “нэхэмжлэл хүлээн авах урьдал нөхцөл”-ийг удаа дараа ижил нөхцөлөөр хангахгүй, зорилтот нэхэмжлэлээ сайжруулахгүй байгаа ЭМБ-д дараах шийтгэлийг ногдуулна. Үүнд:
- 4.10.1. Дараах нөхцөлүүдэд ЭМБ-ын газар дээр нь очиж, тусгайлсан хяналт шалгалт хийнэ. Үүнд:
- 4.10.1.1. Нэхэмжлэлийг буруу, алдаатай бичиж илгээсэн, нэхэмжлэлийг засах эрх олгосон ч гүйцэлдүүлж чадаагүй тохиолдлын тоо нь 4 улирал дараалан буураагүй;
- 4.10.1.2. Бодлогын даалгаврын нөхцөлүүдийг хангаагүй тохиолдлын тоо 4 улирал дараалан буураагүй;
- 4.10.2. Дараах нөхцөлүүдэд тухайн жилийн нийт амжилттай нэхэмжлэлд олгох төлбөрийн дүнгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн торгууль ногдуулах бөгөөд тухайн жилийн сүүлийн нэхэмжлэлд олгох мөнгөн дүнгээс ногдуулна. Үүнд:
- 4.10.2.1. Гэрээлээгүй тусламжийг нэхэмжилсэн тохиолдлын тоо 4 улирал дараалан буураагүй;
- 4.10.2.2. Нэхэмжлэлийг буруу, алдаатай бичиж илгээсэн, нэхэмжлэлийг засах эрх олгосон ч гүйцэлдүүлж чадаагүй тохиолдлуудын тоо нь 8 улирал дараалан буураагүй;
- 4.10.2.3. Бодлогын даалгаврын нөхцөлүүдийг хангаагүй тохиолдлын тоо 8 улирал дараалан буураагүй;
- 4.10.3. Гэрээлээгүй тусламжийг нэхэмжилсэн тохиолдлын тоо 8 улирал дараалан буураагүй тохиолдолд тухайн ЭМБ-ын гэрээг цуцалж, дараагийн нэгдсэн сонгон шалгаруулалтад оруулахгүй.

Тав. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналт

- 5.1. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналт нь а) ЭМБ-ыг код ахиулах буюу иргэн, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээнийхээ төлбөрийг ЭМДЕГ-аас нэхэмжлэхдээ бодит байдлаас хэтрүүлэн, илүү өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний код ашиглан нэхэмжлэх, б) өвчтөний түүхэнд хуурамч баримт хавсаргах, в) тусламж, үйлчилгээ үзүүлээгүй боловч нэхэмжлэх, г) шаардлагатай тусламжийг дутуу үзүүлэх зэрэг хууран мэхлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилготой.
- 5.2. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналтыг баталгаажсан нэхэмжлэлд хийх бөгөөд тухайн сард төлбөрийн хяналтад хамрагдах нийт түүврийн хэмжээ нь ЭМДЕГ-ын хяналт хийх хүний нөөцийн хүчин чадлаас хамаарч, нийт баталгаажсан нэхэмжлэлийн **40** хүртэлх хувьтай тэнцүү байна.

- 5.3. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналтыг үр дүнтэй байлгах зорилгоор зөвхөн хууран мэхлэх үйл ажиллагаа хийсэн байж болзошгүй ЭМБ, тухайн байгууллагын хууран мэхлэх үйл ажиллагаа хийгдсэн байж болзошгүй тусламж, үйлчилгээнд хийнэ.
- 5.4. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналтад хамрагдах хууран мэхлэх үйл ажиллагаа хийсэн байж болзошгүй ЭМБ-ыг “хууран мэхлэх үйл ажиллагааг илрүүлэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу тодорхойлно.
- 5.5. “Хууран мэхлэх үйл ажиллагаа илрүүлэх шалгуур үзүүлэлт” гэж ЭМДЕГ-ын даргын “Нэхэмжлэлийг хянах журам”-аар баталсан “Хууран мэхлэх үйл ажиллагааг илрүүлэх жишиг шалгуур үзүүлэлт” болон ЭМБ-уудын илгээж буй нэхэмжлэлийн зан үйлийн өөрчлөлтөд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр жишиг шалгуурын загварын дагуу боловсруулагдсан бусад шалгуур үзүүлэлтүүд байна.
- 5.6. ЭМДЕГ нь шалгуур үзүүлэлтийн үр дүн гарах боломжтой эсэхээс нь хамааруулан, ямар тусламж, үйлчилгээний төрлийн хүрээнд ямар шалгуур үзүүлэлтийг ашиглахыг тухай бүр шийднэ.
- 5.7. Нийт “Хууран мэхлэх үйл ажиллагаа илрүүлэх шалгуур үзүүлэлт”-үүдийн дийлэнх олонхын гүйцэтгэл нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг ЭМБ-уудын дундаж үзүүлэлтээс 20 хувиар хазайсан ЭМБ-ыг тусламж, үйлчилгээг хууран мэхлэх үйл ажиллагаа хийсэн байж болзошгүй гэж сэжигтэйд тооцон, нэхэмжлэлийн төлбөрийн хяналтад хамруулна.
- 5.8. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналтад хамрагдахаар сонгогдсон ЭМБ-ын уг хяналтад хамрагдах тусламж, үйлчилгээнд дараах шалгуурын аль нэгийг хангасан тусламж, үйлчилгээг сонгож, төлбөрийн хяналтад хамруулна. Үүнд:
 - 5.8.1. ЭМДС-аас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ (тариф) нь өндөр тусламж, үйлчилгээ;
 - 5.8.2. Нэхэмжлэлийн тоо хэмжээ нь их тусламж, үйлчилгээ;
 - 5.8.3. Төсвийн нөлөө өндөр тусламж, үйлчилгээ;
 - 5.8.4. Тодорхой тусламжийн хүрээнд ижил төрлийн эрүүл мэндийн байгууллагаас нэхэмжлэлийн тоо нь хэт их хазайлттай тусламж, үйлчилгээ;
 - 5.8.5. Бусад /ЭМДЕГ-ын нэхэмжлэлийн дүн шинжилгээнд үндэслэн боловсруулагдсан бусад шалгуур үзүүлэлт/
- 5.9. ЭМДЕГ нь “Хууран мэхлэх үйл ажиллагаа илрүүлэх шалгуур үзүүлэлт”-ээр дашбоард хийж, шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн ерөнхий хандлагад байнгын хяналт тавьж ажиллана.
- 5.10. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналтад хамрагдахаар сонгогдсон тусламж, үйлчилгээг “төлбөрийн хяналтын шалгуур”-ыг ашиглан хянах бөгөөд уг шалгуур нь тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд зайлшгүй шаардагдах үндсэн зардал буюу өртгийн чиглүүлэгч байна.
- 5.11. Төлбөрийн хяналтыг зохицуулсан нарийвчилсан журам, “Хууран мэхлэх үйл ажиллагаа илрүүлэх шалгуур үзүүлэлт”, “төлбөрийн хяналтын шалгуур”-ыг ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлан мөрдүүлнэ.
- 5.12. ЭМДЕГ нь төлбөрийн хяналтын үр дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 5.12.1. Төлбөрийн хяналтын шалгуур хангасан тохиолдлын төлбөрийг олгож, шалгуур хангаагүй тохиолдлуудын төлбөрийг олгохгүй.
 - 5.12.2. Төлбөрийн хяналтын шалгуур хангаагүй тохиолдлуудын түүвэр авсан эх олонлогт төлбөрийг хувиар тооцон төлбөрийг бууруулна.
 - 5.12.3. Шалгуур хангаагүй тохиолдлуудыг зөрчлийн санд хууран мэхлэх үйл ажиллагааны төрлүүдээс хамаарах нэршлээс тохирохыг сонгож (“код ахиулах”, “хуурамч”, “завших”) бүртгэнэ.
 - 5.12.4. Хууран мэхлэх үйл ажиллагааны хуримтлагдсан бүртгэл нь нийт нэхэмжлэлийн төлбөрийн 3 хувьд хүрсэн ЭМБ-д цахимаар мэдэгдэл хүргүүлнэ.
 - 5.12.5. Хууран мэхлэх үйл ажиллагааны хуримтлагдсан бүртгэл нь нийт нэхэмжлэлийн төлбөрийн 5 хувьд хүрсэн ЭМБ-ын газар дээр нь очиж, тусгайлсан хяналт шалгалт хийнэ.
 - 5.12.6. Хууран мэхлэх үйл ажиллагааны хуримтлагдсан бүртгэл нь нэхэмжлэлийн төлбөрийн 10 хувьд хүрсэн ЭМБ-ын гэрээг хугацаанаас нь өмнө цуцална.

5.12.7. Энэхүү журмын 5.7-д заасны дагуу 4 улирал дараалан хууран мэхлэх үйл ажиллагаа хийсэн байж болзошгүй ЭМБ-ын газар дээр нь очиж, тусгайлсан хяналт, шалгалтад хамруулна.

Зургаа: Нэхэмжлэлийн чанарын хяналт

- 6.1. Нэхэмжлэлийн чанарын хяналт нь ЭМБ-ыг иргэн даатгуулагчдад чанаргүй тусламж, үйлчилгээг үзүүлэхээс сэргийлэх, илрүүлэх, үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь үндэслэлтэй бодитой эсэхийг баталгаажуулах зорилготой.
- 6.2. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналтад сонгогдоогүй баталгаажсан нэхэмжлэлийг “нэхэмжлэлийн чанарын хяналт”-д хамруулах бөгөөд тухайн сард нэхэмжлэлийн чанарын хяналтад хамрагдах нийт түүврийн хэмжээ нь хяналт хийх хүний нөөцийн хүчин чадлаас хамаарч, нийт баталгаажсан нэхэмжлэлийн 20 хүртэлх хувьтай тэнцүү байна.
- 6.3. Нэхэмжлэлийн чанарын хяналтыг үр дүнтэй байлгах зорилгоор зөвхөн чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн байж болзошгүй ЭМБ-ын чанаргүй хийгдсэн байж болзошгүй тусламж, үйлчилгээнд хийнэ.
- 6.4. Нэхэмжлэлийн чанарын хяналтад хамрагдах чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн байж болзошгүй ЭМБ-ыг “чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн байж болзошгүй ЭМБ-г илрүүлэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу тодорхойлно.
- 6.5. “Чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн байж болзошгүй ЭМБ-г илрүүлэх шалгуур үзүүлэлт” гэж ЭМДЕГ-ын даргын “Нэхэмжлэлийг хянах журам”-аар баталсан “Чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн байж болзошгүй ЭМБ-г илрүүлэх жишиг шалгуур үзүүлэлт” болон ЭМБ-уудын илгээж буй нэхэмжлэлийн зан үйлийн өөрчлөлтөд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нэмэлтээр боловсруулагдсан бусад шалгуур үзүүлэлтийг хэлнэ.
- 6.6. ЭМДЕГ нь шалгуур үзүүлэлтийн үр дүн гарах боломжтой эсэхээс нь хамааруулан, ямар шалгуур үзүүлэлт ашиглахыг тухай бүр шийднэ.
- 6.7. Нийт “Чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн байж болзошгүй ЭМБ-г илрүүлэх жишиг шалгуур үзүүлэлт”-үүдийн дийлэнх олонхын гүйцэтгэл нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг ЭМБ-уудын босго оноог хангаагүй ЭМБ-ыг чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн байж болзошгүй гэж сэжигтэйд тооцон, нэхэмжлэлийн чанарын хяналтад хамруулна. Босго оноог ЭМДЕГ-ын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газар ЭМБ-уудын суурь дата мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тодорхойлно.
- 6.8. Чанарын хяналтад хамрагдахаар сонгогдсон тусламж, үйлчилгээг “Тусламж, үйлчилгээний чанарын хяналтын шалгуур”-ыг ашиглан хянах бөгөөд уг шалгуур нь тухайн тусламж, үйлчилгээний оношийг баталгаажуулах үндсэн үзүүлэлтүүд байна.
- 6.9. “Тусламж, үйлчилгээний чанарын хяналтын шалгуур”-ыг энэхүү журмын Хавсралт 4-т баталсан “Тусламж, үйлчилгээний чанарын хяналтын жишиг шалгуур”-ын загварын дагуу боловсруулж, тухайн тусламж, үйлчилгээний мэргэжлийн салбар зөвлөлийн саналыг үндэслэн, ЭМДЕГ баталж мөрдүүлнэ.
- 6.10. Нэхэмжлэлийн чанарын хяналтад хамрагдахаар сонгогдсон ЭМБ-ын уг хяналтад хамрагдах тусламж, үйлчилгээг сонгох үндсэн шалгуур нь дараах 2 нөхцөлийг бүрэн хангасан тусламж, үйлчилгээ байна. Үүнд:
 - 6.10.1. Энэхүү журмын 6.7-т заасан нэхэмжлэлийн төлбөрийн хяналтад хамрагдах тусламж, үйлчилгээг сонгох шалгуурын аль нэгийг хангасан байх;
 - 6.10.2. Тухайн тусламж, үйлчилгээг хянах “чанарын шалгуур үзүүлэлт”-тэй байх;
- 6.11. Зарим тусламж, үйлчилгээний чанарын хяналтыг хийхэд түлхүүр шалгуурыг ашиглах бөгөөд түлхүүр шалгуурыг хангаагүй тохиолдолд тухайн нэхэмжлэлийг цааш хянахгүй, тухайн нэхэмжлэлийг бүхэлд нь шалгуур хангаагүйд тооцно.
- 6.12. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн тусламж үйлчилгээний чанарын хяналтын үр дүн 90 ба түүнээс дээш оноотой бол тухайн нэхэмжлэлийг “амжилттай нэхэмжлэл” гэж тооцно.
- 6.13. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарын хяналтын үр дүн 70 ба түүнээс дээш оноотой бол тухайн нэхэмжлэлийг “амжилттай нэхэмжлэл” гэж тооцно.

- 6.14. ЭМДЕГ нь чанарын хяналтын үр дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 6.14.1. Чанарын хяналтын шалгуур хангасан тохиолдлын төлбөрийг олгож, хангаагүй тохиолдлуудын төлбөрийг олгохгүй.
 - 6.14.2. Чанарын хяналтын шалгуур хангаагүй тохиолдлуудын түүвэр авсан эх олонлогт төлбөрийг хувиар тооцон төлбөрийг бууруулна.
 - 6.14.3. Шалгуур хангаагүй тохиолдлуудыг зөрчлийн санд “чанаргүй тусламж, үйлчилгээ” гэж бүртгэнэ.
 - 6.14.4. Чанаргүй тусламж, үйлчилгээний хуримтлагдсан бүртгэл нь нийт нэхэмжлэлийн төлбөрийн 3 хувьд хүрсэн ЭМБ-д цахимаар мэдэгдэл хүргүүлнэ.
 - 6.14.5. Чанаргүй тусламж, үйлчилгээний хуримтлагдсан бүртгэл нь нийт нэхэмжлэлийн төлбөрийн 5 хувьд хүрсэн ЭМБ-ын газар дээр нь очиж, тусгайлсан хяналт, шалгалт хийнэ.

Долоо. Төлбөрийн хэмжээг нягтлах хяналт

- 7.1. Төлбөрийн хэмжээг нягтлах хяналт нь ЭМБ нь иргэн даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн төлбөрийг хэмжээг зөв тооцсон эсэхийг хянаж, залруулах зорилготой.
- 7.2. Төлбөрийн хэмжээг нягтлах хяналтыг нэхэмжлэлийн төлбөрийн болон чанарын хяналтын шалгуурыг хангаж, төлбөр олгогдохоор тооцогдсон баталгаажсан нэхэмжлэлд хийнэ.
- 7.3. Төлбөрийн хэмжээг нягтлах хяналтыг дараах шалгуурын дагуу цахимаар гүйцэтгэнэ. Үүнд:
 - 7.3.1. Тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн төрлийг оновчтой тогтоосон эсэх
 - 7.3.2. Хамтын төлбөрийн хэмжээг оновчтой тогтоож, ЭМДС-аас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээг зөв нэхэмжилсэн эсэх
- 7.4. ЭМДЕГ нь төлбөрийн хэмжээг нягтлах хяналтын үр дүнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 7.4.1. Төлбөрийн хэмжээг буруу нэхэмжилсэн нэхэмжлэлийг шууд засварлаж, засварласан төлбөрийн хэмжээг төлбөрийг гүйцэтгэнэ.
 - 7.4.2. Төлбөрийн хэмжээ засварласан батлагдсан нэхэмжлэлийн мэдээллийг холбогдох ЭМБ харах, мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 7.4.3. Төлбөрийн хэмжээг нягтлах хяналтын үр дүнд үндэслэн ЭМБ-уудад зөвлөмж хүргүүлнэ.

Найм. Эмнэлзүйн аудит

- 8.1. Эмнэлзүйн аудитад а) хамгийн их нэхэмжилдэг тусламж, үйлчилгээ б) эмнэлзүйн хувьд ач холбогдолтой тусламж, үйлчилгээ в) олон нийтийн анхаарлын төвд байдаг тусламж, үйлчилгээнүүдээс дараах шалгууруудыг бүрэн хангасан тусламж, үйлчилгээний төрлийг хамруулна. Үүнд:
 - 8.1.1. Эмнэлзүйн аудитын үнэлгээгээр чанарыг сайжруулах боломжтой тусламж, үйлчилгээ
 - 8.1.2. Үнэлгээг хийхэд хүндрэл, чирэгдэлгүй буюу өгөгдөл цуглуулах боломжтой байх байх
 - 8.1.3. Тухайн сэдвийн хүрээнд шинжлэх ухааны нотолгоотой байх /эмнэлзүйн удирдамж, хөтөч/
- 8.2. Эмнэлзүйн аудитыг батлагдсан удирдамж болон “эмнэлзүйн аудитын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу хийх бөгөөд удирдамж, шалгуур үзүүлэлтийг ЭМДЕГ-ын дарга батлан мөрдүүлнэ.
- 8.3. Жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан дараа жилийн эмнэлзүйн аудит хийх төлөвлөгөө, удирдамжийг батлах бөгөөд удирдамжид дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

- 8.3.1. Эмнэлзүйн аудит хийх сэдэв, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн техникийн тодорхойлолт;
 - 8.3.2. Өгөгдөл цуглуулах, өгөгдлийг шалгах, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, ЭМБ-ыг эрэмбэлэх аргууд;
 - 8.3.3. Эмнэлзүйн аудитад хамрагдах ЭМБ, түүвэр, шаардагдах төсөв;
 - 8.3.4. Эмнэлзүйн аудитыг хийх багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, ажиллах хугацаа;
 - 8.3.5. Эмнэлзүйн аудитын тайлангийн загвар, гарсан үр дүнг хуваалцах арга;
 - 8.3.6. Эмнэлзүйн аудитын үр дүнд хэрэгжүүлэх хариу арга хэмжээ авах, хэрэгжилтийг үнэлэх аргачлал зэрэг болно.
- 8.4. Эмнэлзүйн аудитын үнэлгээний шалгуур үзүүлэлт нь энэхүү журмын Хавсралт 5- аар батлагдсан жишиг шалгуур үзүүлэлтийн дагуу боловсруулагдах бөгөөд ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлан мөрдүүлнэ.
- 8.5. ЭМДЕГ нь жилд 2-оос доошгүй тусламж, үйлчилгээнд эмнэлзүйн аудит хийх бөгөөд эмнэлзүйн аудит хийх тусламж, үйлчилгээний хүрээг жил бүр нэмэгдүүлнэ.
- 8.6. ЭМДЕГ нь эмнэлзүйн аудитын үр дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 8.6.1. Эмнэлзүйн аудитад хамрагдсан байгууллагуудыг оноогоор нь жагсаана.
 - 8.6.2. Нийлбэр оноогоор эхний байранд эрэмбэлэгдсэн ЭМБ-уудад батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн урамшуулал олгоно.
 - 8.6.3. Нийлбэр оноогоор 4 улирал дараалан сүүлийн байранд эрэмбэлэгдсэн ЭМБ-ын газар дээр нь очиж, тусгайлсан хяналт, шалгалт хийнэ.
 - 8.6.4. Нийлбэр оноогоор 6 улирал дараалан сүүлийн байранд эрэмбэлэгдсэн ЭМБ-ын нийт тусламж, үйлчилгээний амжилттай нэхэмжлэлд олгох төлбөрийг 1 хувиар бууруулж олгоно.
 - 8.6.5. Нийлбэр оноогоор 8 улирал дараалан сүүлийн байранд эрэмбэлэгдсэн ЭМБ-ын нийт тусламж, үйлчилгээний амжилттай нэхэмжлэлд олгох төлбөрийг 2 хувиар бууруулж олгоно.
 - 8.6.6. ЭМЯ-д эмнэлзүйн аудитын тайланг хүргүүлнэ.
 - 8.6.7. Тусламж, үйлчилгээний чанар сайжруулах дэмжлэгт хөтөлбөрт ЭМБ-уудыг сайн дурын болон зайлшгүй нөхцөлөөр хамруулна.
 - 8.6.8. Эмнэлзүйн аудитын үр дүнд үндэслэн ЭМБ-уудад анхаарах асуудал, эмнэлзүйг сайжруулах зөвлөмж, чиглэлийг хүргүүлнэ.
 - 8.6.9. Эмнэлзүйн аудитын үр дүнг байгууллага тус бүрээр олон нийтэд ил тод байршуулж, иргэн даатгуулагчийг үйлчилгээ авах ЭМБ-ын сонголт хийх, шийдвэр гаргах мэдээллээр хангана.

Ес. ЭМБ дээр хийх тусгайлсан хяналт шалгалт

- 9.1. ЭМБ дээр хийх тусгайлсан хяналт шалгалтын зорилго нь тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, хууран мэхлэх үйл ажиллагаанаас сэргийлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 9.2. Дараах тохиолдолд холбогдох ЭМБ-ын газар дээр нь очиж, тусгайлсан хийх хяналт шалгалтыг хийнэ. Үүнд:
 - 9.2.1. Энэхүү журмын 4.8.1, 5.12.5, 5.12.7, 6.11.5, 7.6.3-т заасан ЭМБ дээр хяналт шалгалт хийх нөхцөл хангагдсан тохиолдол;
 - 9.2.2. ЭМБ-ын тусламж, үйлчилгээний чанарын асуудлаар олон нийтээс шүгэл үлээсэн, гомдол ирүүлсэн тохиолдол;
- 9.3. ЭМБ-ын газар дээр нь очиж, тусгайлсан хяналт шалгалт хийх нөхцөл бүрдсэн тухай бүр хяналт, шалгалт хийх удирдамжийг ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлах бөгөөд удирдамжид хяналт, шалгалт хийх ЭМБ, оролцох мэргэжилтэн, үргэлжлэх хугацаа, зарцуулах төсөв, хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх арга, шаардлагатай нэмэлт мэдээлэл, бичиг баримт, тайлангийн загвар зэргийг тусгана.

- 9.4. ЭМБ дээр хийх тусгайлсан хяналт, шалгалт хийхдээ хяналт шалгалтын цар хүрээнээс хамаарч 9.4.1-9.4.6 дахь арга хэмжээг бүгдийг эсхүл хэсэгчлэн, 9.1.7 дахь арга хэмжээг бүх тохиолдолд заавал авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.4.1. ЭМБ-ын дэд бүтэц, тоног төхөөрөмж, хүний нөөцийг шалгана /Сонгон шалгаруулалтын үед өгсөн мэдээлэл нь үнэн зөв эсэх, тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадамжтай эсэх, тоног төхөөрөмж нь ажилладаг эсэх, ашиглалтын хугацаа нь хүчинтэй эсэх, чанарын хяналтад хамрагдсан эсэх гэх мэт/
 - 9.4.2. ЭМБ-ын тусламж, үйлчилгээний тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, бусад холбогдох бичиг баримтыг шалгана.
 - 9.4.3. ЭМБ-ын санхүүгийн бичиг баримтыг шалгана /ЭМДС-аас олсон орлогыг тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад зарцуулагдаж буй эсэх гэх мэт./
 - 9.4.4. ЭМБ-ын эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, чанар, тасралтгүй байдалд шалгалт хийнэ. /Тухайлбал: Эм, эмнэлгийн хэрэгслийн орлого зарлагыг өвчний түүхэнд бичигдсэн хэрэглээтэй тулгах, ЭМДС-аас олсон орлогыг үр ашигтай зарцуулж буй эсэхийг шалгах хүрээнд гол нэрийн эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг нь зах зээлийн үнэтэй харьцуулах гэх мэт./
 - 9.4.5. Өвчтөний түүхийг шалгана.
 - 9.4.6. Үйлчлүүлэгч эмнэлгийн хаалгаар ороод эмнэлгээс гарах хүртэлх урсгалыг дагаж судална.
 - 9.4.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч, эмнэлгээс гарсан үйлчлүүлэгчтэй ярилцлага хийнэ. Сэтгэл ханамжийн судалгаа авна.
- 9.5. ЭМДЕГ нь ЭМБ дээр хийх тусгайлсан хяналт шалгалтын үр дүнг үндэслэн, зөрчил гаргасан ЭМБ-д дараах шийтгэлийг ногдуулна. Үүнд:
- 9.5.1. Хууран мэхлэх үйл ажиллагаа нотлогдсон тохиолдолд:
 - 9.5.1.1. Эхний удаа хууран мэхлэх үйл ажиллагаа нотлогдсон тохиолдолд хууль бус орлогыг буцааж төлүүлэх хуваарийг гаргаж, авлага тооцно.
 - 9.5.1.2. Хоёр дахь удаа хууран мэхлэх үйл ажиллагаа нотлогдсон тохиолдолд хууль бус орлогын хэмжээг 2 дахин үржүүлсэнтэй тэнцэхүйц мөнгөн торгууль ногдуулж, тухайн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг хүлээн авахыг 1 сарын хугацаатай түдгэлзүүлнэ.
 - 9.5.1.3. Гурав дахь удаа хууран мэхлэх үйл ажиллагаа нотлогдсон тохиолдолд хууль бус орлогын хэмжээг 4 дахин үржүүлсэнтэй тэнцэхүйц мөнгөн торгууль ногдуулах ба тухайн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг хүлээн авахыг 3 сарын хугацаатай түдгэлзүүлнэ.
 - 9.5.1.4. Дөрөв дэх удаа хууран мэхлэх үйл ажиллагаа нотлогдсон тохиолдолд хууль бус орлогын хэмжээг 4 дахин үржүүлсэнтэй тэнцэхүйц мөнгөн торгууль ногдуулах ба тухайн тусламж, үйлчилгээний гэрээг цуцална.
 - 9.5.1.5. Тав ба түүнээс дээш удаа хууран мэхлэх үйл ажиллагаа нотлогдсон тохиолдолд тухайн ЭМБ-тай 5 жил тухайн тусламж, үйлчилгээгээр гэрээ байгуулахгүй.
 - 9.5.1.6. Нотлогдсон ноцтой асуудлын талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэнэ.
 - 9.5.1.7. Хууль зөрчсөн тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.
 - 9.5.2. Иргэнээс үндэслэлгүй төлбөр авсан нь нотлогдсон тохиолдолд:
 - 9.5.2.1. Эхний тохиолдолд төлбөрийг иргэнд буцааж төлүүлэх ба түүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгуулийг ЭМДЕГ-т төлнө.
 - 9.5.2.2. Хоёр дахь тохиолдолд төлбөрийг иргэнд буцааж төлүүлэх ба иргэнд төлөх төлбөрийн хэмжээг 2 дахин үржүүлсэнтэй тэнцэх мөнгөн торгуулийг ЭМДЕГ-т төлнө.
 - 9.5.2.3. Гурав дахь тохиолдолд төлбөрийг иргэнд буцааж төлүүлэх ба иргэнд төлөх төлбөрийн хэмжээг 4 дахин үржүүлсэнтэй тэнцэх мөнгөн торгуулийг ЭМДЕГ-т төлнө.

9.5.2.4. Нотлогдсон ноцтой асуудлын талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэнэ.

9.5.3. Чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн нь нотлогдсон тохиолдолд:

9.5.3.1. Эхний удаагийн тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг хүлээн авахыг 3 сарын хугацаатай түдгэлзүүлж, албан даалгавар өгнө.

9.5.3.2. Хоёр дахь удаагийн тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг хүлээн авахыг 6 сарын хугацаатай түдгэлзүүлж, албан даалгавар өгнө.

9.5.3.3. Гурав дахь удаагийн тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг хүлээн авахыг 1 жилээр түдгэлзүүлж, албан даалгавар өгөх ба ЭМЯ-нд тухайн ЭМБ-ын тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх/хүчингүй болгох арга хэмжээний саналыг, ЭМБ дээр хийсэн тусгайлсан хяналт, шалгалтын үр дүнгийн хамт хүргүүлнэ.

9.5.3.4. Гурав дахь удаагийн тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний гэрээг цуцлана.

9.5.3.5. Тухайн тусламж, үйлчилгээг түдгэлзүүлсэн хугацаанд худалдан авагчаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн тусламжийн гэрээг хугацаанаас өмнө цуцална.

9.5.3.6. Тухайн ЭМБ-тай 5 жил тухайн тусламж, үйлчилгээгээр гэрээ байгуулахгүй.

9.5.3.7. Нотлогдсон ноцтой асуудлын талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэнэ.

9.5.3.8. Хууль зөрчсөн тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

Арав. Гэрээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

10.1 Гэрээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээний зорилго нь тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад оршино.

10.2 Гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээг ЭМДҮЗ-өөр батлагдсан гэрээний үлгэрчилсэн загварын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтээр хийнэ.

10.3 Гэрээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон холбогдох дата мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулж, жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ЭМДЕГ-тай гэрээ бүхий нийт ЭМБ-ыг хамруулан хийнэ.

10.4 ЭМДЕГ нь гэрээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээний үр дүнг үндэслэн, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

10.4.1 Гэрээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээний үр дүн нь 90 хувь ба түүнээс дээш тохиолдолд тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд ЭМБ-т санхүүгийн урамшуулал олгоно.

10.4.2 Гэрээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээний үр дүн нь 69 хувь ба түүнээс доош тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцална.

10.4.3 Гэрээний гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг ил тод, нээлттэй байршуулна.

Арван нэг. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа

11.1. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны зорилго нь ЭМБ-аас иргэн, даатгуулагчид үзүүлж буй тусламж, үйлчилгээнд үнэлэлт өгөх, сайжруулах арга замыг тодорхойлж, ЭМБ-ыг үйл ажиллагаагаа сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

11.2. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг цахим мэдээллийн систем эсвэл хөндлөнгийн судалгааны байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

11.3. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг судалгаа хийж буй зорилгоос хамааруулан боловсруулах бөгөөд судалгааны удирдамж, асуумжийг ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлан мөрдүүлнэ. Журмын хавсралт 6-д заасан жишиг асуумжаар авч болно.

- 11.4. ЭМДЕГ нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 11.4.1. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг тухайн байгууллагатай хийсэн гэрээг дүгнэх гэрээний шалгуур үзүүлэлтэд хамруулж, дүгнэнэ.
- 11.4.2. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийн, ЭМБ-уудад зөвлөмж хүргүүлнэ.
- 11.4.3. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг нийтэд ил тод байршуулна.

Арван хоёр. Чанар, төлбөрийн хяналттай холбоотой маргааныг шийдвэрлэх

